

How are we using time use data in Mongolia?

Otgontugs Banzragch¹

Myagmarsuren Boldbaatar²

¹ Department of economics, National University of Mongolia,

² Department of economics, National University of Mongolia

Abstract: Time use surveys can comprehensively measure the time spent by citizens on daily activities and are an important source of data for studying a variety of socio-economic phenomena, including paid and unpaid work, gender inequality, the care economy, and time poverty. The National Statistical Committee of Mongolia has conducted a total of six Time Use Surveys since 2000, collecting data from a total of 31,322 households, demonstrating progress in survey methodology, sample representativeness, and data accessibility. Meanwhile, the research community is using the time use data extensively, but the lack of using it among policymakers is hindering data-driven decision-making in economic and social policies. This article reviews the political, economic, and social reasons for implementing the Time Use Surveys in Mongolia, as well as the research methodology, data use, and implications for policy development, and suggests ways to use the data more effectively in the future.

Key words: Time use data, care economy, unpaid care work, time use data demand
JEL код: C83, J16, O53

¹otgontugs@num.edu.

²myagmarsuren.b@num.edu.mn

Цаг ашиглалтын өгөгдлийг бид хэрхэн хэрэглэж байна вэ?

Б.Отгонтөгс³

Б.Мягмарсүрэн⁴

¹ МУИС, Эдийн засгийн тэнхим,

² МУИС, Эдийн засгийн тэнхим

Абстракт: Цаг ашиглалтын судалгаа нь иргэдийн өдөр тутмын үйл ажиллагаанд зарцуулж буй цагийг бүрэн цогц байдлаар хэмжих боломжтой бөгөөд цалин хөлстэй болон цалин хөлсгүй хөдөлмөр, жендерийн тэгш бус байдал, асрахуйн эдийн засаг, цагийн ядуурал зэрэг нийгэм-эдийн засгийн олон талт үзэгдлийг судлах чухал өгөгдлийн эх сурвалж болдог. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо 2000 оноос хойш нийт зургаан удаа Цаг ашиглалтын судалгааг зохион байгуулж, нийтдээ 31,322 өрхөөс өгөгдөл цуглуулсан нь судалгааны аргачлал, түүврийн төлөөлөх чадвар, өгөгдлийн хүртээмжийн хувьд ахиц дэвшил гарсныг харуулж байна. Судлаачид уг өгөгдлийг өргөн ашиглаж байгаа боловч бодлого боловсруулагчдын дунд хэрэглээ хангалтгүй байгаа нь эдийн засаг, нийгмийн бодлогод өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг саатуулж байна. Энэхүү өгүүлэл нь Монгол Улсад ЦАС-ыг хэрэгжүүлэх болсон улс төр, эдийн засаг, нийгмийн шалтгаан, судалгааны аргачлал, өгөгдлийн хэрэглээ, бодлого боловсруулахад үзүүлж буй нөлөөллийг тоймлон дүгнэж, цаашид өгөгдлийг илүү үр дүнтэй ашиглах аргамзыг санал болгож байна.

Түлхүүр үг: Цаг ашиглалтын судалгаа, Асрахуйн эдийн засаг, Цалин хөлсгүй асрах ажил, цаг ашиглалтын судалгааны хэрэглээ

JEL код: C83, J16, O53

³otgontugs@num.edu.

⁴myagmarsuren.b@num.edu.mn

1 дүгээр хэсэг. Оршил

Цаг ашиглалтын өгөгдөл (ЦАӨ), цаг ашиглалтын судалгаа (ЦАС) нь хоёр ялгаатай ойлголтууд юм. Цаг ашиглалтын өгөгдөлд хүмүүсийн, аж ахуйн нэгжүүдийн цагийн ашиглалт, хөдөлмөрийн бүтээмж, сайн сайхан байдлын хэмжилт хийх боломжтой хувьсагч, өгөгдлүүд багтдаг бол ЦАС нь зөвхөн хувь хүмүүсийн цагаа хэрхэн зарцуулж байгааг өрхүүд, хувь хүмүүсээс асууж, өдрийн тэмдэглэл хөтлүүлэн асууж, мэдээлэл, өгөгдөл цуглуулж авдаг түүвэр судалгаа юм (Үндэсний статистикийн хороо, 2023). Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс (НҮБХХ) 2018 онд гаргасан тайланд “ЦАС нь хүмүүс цагаа олон төрлийн үйл ажиллагаанд нэг бүтэн өдрийн хувьд эсвэл нэг долоо хоногийн туршид хэрхэн хуваарилж байгааг бүрэн цогц байдлаар харуулж, хэмжиж чадах чухал түүвэр судалгаа бөгөөд Үндэсний Тооцооны Системд бүртгэгддэг болон бүртгэгдэхгүй байгаа үйл ажиллагааг нэгдсэн байдлаар харуулж чадах судалгаа юм” гэж дүгнэсэн байна (ILO, UNDP, 2018). Өндөр хөгжилтэй орнууд болон хөгжиж буй орнууд ЦАС-ны үр дүнг өөрсдийн тулгарч буй нийгмийн хөгжлийн, ялангуяа жендэрийн тэгш бус байдлаас үүсэж байгаа асуудлуудыг шийдэх бодлогын судалгаанд өргөн ашиглаж байна.

ЦАС нь эдийн засагчдын хэмжиж чаддаггүй “Асрахуйн эдийн засаг”-ийн талаар хамгийн чухал мэдээлэл, өгөгдлийг нийлүүлдэг чухал судалгаа юм. “Асрахуйн эдийн засаг” гэдэг нь аливаа асрахуйн ажлын санхүүжилт, нийлүүлэлт, зохицуулалт хийж байгаа салбарыг хэлнэ (UNRISD, 2010). Асрахуйн ажил, асрахуйн эдийн засаг бол нийт эдийн засгийн өсөлт, тогтвортой, эдийн засгийн хөгжлийн тулгуур салбар юм (Elson ба Gagatay, 1995, World Bank, 2011). Одоогийн байдлаар дэлхийн 85 улс орон 1966 оноос хойш ЦАС-г зохион байгуулж ирсэн ба 2000 оноос хойш улс орнууд илүү олноор цуглуулж байна (Үндэсний статистикийн хороо (ҮСХ), 2024). Түүнчлэн ЦАС нь Тогтвортой Хөгжлийн Зорилгын 5.4.1-т заасан “Гэрийн болон асран халамжлах үнэ төлбөргүй хөдөлмөрт зарцуулсан цагийн эзлэх хувь, хүйс, нас, байршлаар” хэмжиж чадах, улмаар уг чухал зорилгын хэрэгжилт, явцыг үнэлэх боломжийг олгодог судалгаа юм.(ҮСХ,2016)⁵ ЦАС-с гарсан өгөгдөл дээр үндэслэн бодлого боловсруулагч нар улсын хэмжээнд цалин хөлсгүйгээр хүн асрах, гэрийн ажил хийх нь их байгааг хүлээн зөвшөөрч, өрх, гэр бүлийн доторх

⁵<https://sdg.1212.mn/Home/Detail?id=5>

цалин хөлсгүй ажлыг хуваалцах явдлыг дэмжих, түүний ач холбогдлыг эрхэмлэх төрийн үйлчилгээ, дэд бүтэц, нийгмийн хамгааллын бодлогоор цалин хөлсгүй асрах ажлыг зохицуулах, бууруулах бодлого явуулах хэрэгтэй гэж судлаачид үздэг (International Labor Organization, 2018, Floro and King, 2016).

Бусад орнуудад ЦАС-ны албан ёсны тайлангаас гадна, судалгааны тоон өгөгдлийг ашиглан хийсэн судалгааг макро эдийн засаг, эдийн засгийн өсөлт, хөдөлмөрийн эдийн засаг, нийгмийн хамгааллын бодлого зэрэг чухал шийдвэр гаргахад ашиглаж байна. Их Британийн эдийн засагчид Coyle, Nakamura нар цаг ашиглалтын өгөгдөл ашиглан нийгмийн гишүүдийн сайн сайхан байдалд ямар өөрчлөлт орж байгааг хэмжиж болно гэж дүгнэсэн байна. Тиймээс ЦАС нь зөвхөн иргэдийн цагаа хэрхэн зарцуулж байгаа талаарх судалгаа биш, цаашдаа эдийн засгийн салбар болгонд зарцуулж байгаа цаг, давхардаж хийгдэж байгаа цалин хөлстэй болон цалин хөлсгүй ажлуудыг хэмжиж, улмаар энэ нь Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ)-ий хэмжээнд нөлөөлж буй эсэхийг судлахад ашиглаж болох өгөгдөл гэдгийг судлаачид тэмдэглэж байна (Coyle, Nakamura 2022). Тиймээс ЦАС нь бодлогын судалгаанд чухал ач холбогдолтой өгөгдлийг агуулж байгаа судалгаа юм.

Асрахуйн ажил цалин хөлстэй эсвэл цалин хөлсгүй байдаг. Цалин хөлсгүй асрахуйн ажил Монгол улсын эдийн засаг, нийгмийн амьдралд чухал ач холбогдолтой боловч бодлогын түвшинд авч хэлэлцэгдэхгүй байгаа нь уг салбарын талаарх ойлголт, бүтээж байгаа нэмүү өртгийн нарийвчилсан хэмжилт хийгдэхгүй байгаатай холбоотой. Мөн асрахуйн эдийн засгийн сектор макро эдийн засгийн ихээхэн том салбар болох талаар ойлголт ховор байгаатай, хүйсээс хамаарсан өгөгдлийн цоорхой байгаатай холбоотой юм. Цаг ашиглалтын түүвэр судалгаа нь энэ холбооснуудыг нэгтгэх чухал үүрэгтэй судалгаа юм. ҮСХ 2000 оноос эхлэн 5 удаа ЦАС хийсэн бөгөөд эдгээр өгөгдөл нь Монгол Улс дах цалин хөлстэй болон цалин хөлсгүй ажлын цар хэмжээг хэмжихэд, хөдөө хотын ялгаа, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ажлын ялгааг хэмжихэд хамгийн чухал өгөгдөл юм. Судалгаа ихээр хийгдэх тусам нийгмийн бодлого, нийгмийн хамгааллын талаар үр дүнтэй бодлого хэрэгжүүлэх боломж илүү нэмэгдэх юм.

Энэ өгүүллийн судалгааны асуулт нь нэгдүгээрт, Монгол Улсад ЦАС-г зохион байгуулах болсон улс төр, эдийн засаг, нийгэм, хүн амын хөгжлийн шалтгааныг тодруулах, хоёрдугаарт, уг судалгааны 2000-2023 оны хооронд хийгдсэн түүврийн

хэмжээ, түүврийн дизайн, түүвэрлэлтийн аргыг тоймлох бөгөөд гуравдугаарт, уг судалгааны тайлан, өгөгдлийг төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд болон их дээд сургууль эрдэм шинжилгээний байгууллагууд хэрхэн ашиглаж байгааг судалж, дүн шинжилгээг хийх зорилготой. Судалгааны аргын хувьд 2000 оноос хойш хийгдсэн ЦАС-ны эхлэлийг тавьсан мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцлага явах, тус хорооноос гарсан судалгааны тайлангуудыг судлах, тоймлох, ЦАС-ны өгөгдөл ашиглаж олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд хэвлүүлсэн өгүүлүүдийн тойм гаргах, макро эдийн засгийн, хөдөлмөрийн, хүн ам зүй, нийгмийн бодлогын чиглэлд бодлого боловсруулагчид, судлаачидтай ярилцлага хийх зэрэг аргуудыг хэрэглэв.

Энэ өгүүллийн ач холбогдол нь хэмжигдэхгүй байгаа эдийн засгийн нэг гол салбар болох асрахуйн салбарыг хэмжихэд ЦАС чухал ач холбогдолтой болохыг, уг судалгаагаар өгөгдлийн цоорхойг сайн нөхөж чадвал тухайн макро эдийн засгийн болон нийгмийн бодлогуудын холбоосыг сайн хийх, түгээмэл болж ирж байгаа хиймэл оюун ухаан, технологи, алгоритм нь тэгш бүрэн өгөгдлөөр хангагдаж чадвал хүмүүсийн, аж ахуйн нэгжүүдийн сайн сайхан байдал сайжирч ирэх боломжтойг харуулж байгаад оршино.

Өгүүлэл 4 хэсгээс бүрдэх бөгөөд оршлоос гадна, хоёрдугаар хэсэгт ЦАС-г зохион байгуулах болсон улс төр, эдийн засаг, нийгэм, хүн амын хөгжлийн шалтгааныг тодруулах, уг судалгааны 5 удаагийн түүврийн хэмжээ, түүврийн дизайн, түүвэрлэлтийн аргыг тоймлоно. Гуравдугаар хэсэгт Монгол улсын бодлого боловсруулагчдын дунд ЦАС-г бодлогын шийдвэр гаргахад хэрхэн ашиглаж байгаа талаар хийсэн ярилцлагын үр дүнг танилцуулна. Дөрөвдүгээр хэсэгт дүгнэлт, зөвлөмжийг харуулна.

2 дугаар хэсэг. Цаг ашиглалтын судалгааг Монгол Улсад хэрэгжүүлэх шалтгаан, явц, товч түүх.

1921-1991 онуудын хооронд Монгол Улс социалист улс байсан тул ҮСХ (тухайн үеийн Статистикийн Төв Газар) нь голчлон улсын эдийн засгийн хэмжээг тооцох, хүн амын болон малын тооллого хийх, аж ахуйн ерөнхий гол гол тооллого, судалгааг хийдэг байсан боловч өрх гэрүүд, хувь хүмүүсийн, эрэгтэй эмэгтэй хүүхдийн цаг ашиглалтын талаарх нарийвчилсан түүвэр судалгааг хийдэггүй байв. 1991 онд эхэлсэн шилжилтийн эхний жилүүдэд Монгол Улс эдийн засгийн нийт хэмжээг Үн-

дэсний Тооцооны Системээр тооцож гаргадаг болох, эдийн засгийн өсөлт, үнийн түвшний өөрчлөлт хэлбэлзэл, салбаруудын нийт эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тооцох, улмаар нийт эдийн засгийг бүрдүүлж байгаа өрхүүд, иргэдийн орлого, зарлага, ажил хийх эрэлт хэрэгцээ, боловсрол, эрүүл мэндийн байдал, сүүдрийн эдийн засаг ямар түвшинд байгааг олон улсын стандартаар хэмжих хэрэгтэй болсон юм.

ҮСХ Дэлхийн Банкны санхүүжилт болон техникийн тусламжтайгаар 1995 болон 1998 онд анх Living Standard Measurement Surveys (LSMS) буюу Өрхүүдийн Нийгэм-Эдийн засгийн түүвэр судалгааг хамтран хийснээр анх удаа улсыг төлөөлөх чадвартай том түүврийг өрх, иргэдээс шууд очиж, асуулгаар авах судалгааг хийж эхлүүлсэн юм. Тэр үед, 1995 онд БНХАУ-ын нийслэл Бээжин хотод “Дэлхийн Эмэгтэйчүүдийн хурал” хуралдаж, эмэгтэйчүүдийн эрхийн талаарх арга хэмжээг нэгтгэсэн Бээжингийн Тунхаглалыг баталсан билээ. Мөн 1995 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) анх удаа хүний хөгжлийн тайланг гаргаж, олон улсын тоон өгөгдөл дээр тулгуурлан хүний хөгжлийн индексийг хэмжиж гаргасан юм. 1995 онд Бээжин хотод хуралдсан “Дэлхийн Эмэгтэйчүүдийн хуралд” Монгол Улсын Засгийн газрын гишүүд оролцсон бөгөөд Монгол Улсын хувьд охид эмэгтэйчүүдийн талаар, тэдний орлого, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөрийн зах зээлд оролцож байгаа байдал, сайн сайхан байдлын талаар илүү нарийвчилсан мэдээлэл, судалгаа, өгөгдөл манай улсад нэн шаардлагатай болохыг ойлгосон чухал үе байсан юм. Улс төрийн талаас эдгээр мэдээлэл, өгөгдлийг цуглуулах, цаашдын бодлогын шийдэлд хэрэглэх нь чухал байгааг ойлгож мэдэрсэн учраас засгийн газрын зүгээс ҮСХ-ны удирдлагад айл өрх, ард иргэдээс буюу охид, эмэгтэйчүүд болон хөвгүүд, эрчүүдээс авах түүвэр судалгааг өргөжүүлэх талаар олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгтэй тухай даалгавар, чиглэл өгч байсан тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) болон НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн (НҮБХХ) 2018 онд гаргасан тайланд дурдсан байна.

Эмэгтэйчүүдийн хувьд тоон өгөгдөл цуглуулахын сацуу нийт эдийн засаг, нийгмийн хувьд, анх удаа бий болсон үзэгдлүүд болох ажилгүйдлийн түвшин, инфляцын түвшний өөрчлөлт, ядуурлын болон тэгш бус байдлын түвшин, улс доторх иргэдийн шилжих хөдөлгөөн, сүүдрийн эдийн засгийн хэмжээг хотын болон хөдөөгийн өрхүүдийн хувьд тодорхойлох зэрэг томоохон судалгаа, тооллого, түү-

вэрчилсэн судалгааны ажлуудыг хийх шаардлагатай болсон юм. Иймээс Үндэсний статистикийн хорооны удирдлага НҮБ-ийн 1993 онд гаргасан Systems of National accounts (SNA) буюу Үндэсний Тооцооны Системийн дагуу тооцоо, хэмжилт хийх сургалтуудад олон тооны албан хаагчдыг хамруулан сургасан нь дараа үедээ түүврийн хэмжээ их, цаг хугацаа ихээхэн шаардах, үндэсний хэмжээний төлөөлөл бүхий түүвэр судалгаа, тэр дундаа Цаг ашиглалтын түүвэр судалгааг 2000 онд туршилтын журмаар хийх боломж, ур чадварыг бий болгосон юм. Ийнхүү 2000 оны дөрөвдүгээр сард туршилтын ЦАС-г ҮСХ, Монгол Улсад ажиллаж эхэлсэн НҮБХХ, мөн Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамтай хамтран нийслэл хотын 1,086 өрхийг хамруулан хийсэн. 24 цагийн туршид хувь хүмүүс цагаа хэрхэн зарцуулж байгааг асуулгаар болон, түүвэрт ногдсон хувь хүний өөрөө хөтлөх, өөрөө мэдээлэх аргачлалыг Монгол Улсын статистикийн түүхэнд анх нэвтрүүлсэн юм. ОУХБ болон НҮБХХ-өөс 2018 онд гаргасан тайланд “2000 онд анх зохион байгуулсан Цаг Ашиглалтын туршилтын судалгаа нь Монгол хүмүүсийн цагаа цалин хөлстэй болон цалин хөлсгүй ажилд хэрхэн зарцуулж байгааг хэмжиж болох төдийгүй, ийм төрлийн судалгааг хүн амын болон жендерийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх хэрэгтэйг харуулсан туршилт болсон байна” (ILO, UNDP, 2018) хэмээсэн байдаг.

Цаг ашиглалтын өгөгдөл цуглуулдаг гол институц нь ҮСХ бөгөөд 2000 онд ЦАС-г туршилтын журмаар явуулж хэрэгжүүлсний дараа 1997 онд батлагдсан Статистикийн тухай хуульд ЦАС-г дөрвөн жилд нэг удаа улсын төсвөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх тухай нэмэлт өөрчлөлтийг 2004 онд оруулсан юм (ЭЗМНС, 2024). Улмаар ҮСХ 2007 онд 3,200 өрхийг хамарсан бүрэн хэмжээний түүврийн дагуу Цаг ашиглалтын судалгааг дөрвөн улирлын туршид амжилттай зохион байгуулсан. Ийнхүү хамгийн анхны бүрэн хэмжээний ЦАС-г ҮСХ нь НҮБХХ болон Шведийн Олон Улсын Хөгжлийн Хамтын Ажиллагааны агентлагтай хамтран хэрэгжүүлсэн бөгөөд уг түүвэр судалгааны үр дүнг 2008 онд Англи, Монгол хэл дээр хэвлүүлсэн ба тэд хамгийн анхны ЦАС-ны өгөгдлийн боловсруулах ажлыг The Census and Survey Processing System (CSPRO) болон the Statistical Package for Social Statistics (SPSS) программ ашиглан боловсруулсан байна (Banzragch, 2018).

Монголын удаах ЦАС-г 2011 онд улсын хэмжээнд болон бүсийн түвшинд төлөөлөл бүхий 3,998 өрхүүдээс авсан ба эдгээр өрхүүдийн нийт 12 болон түүнээс дээш настай хүмүүсээс асуулгаар болон өдрийн тэмдэглэл хөтлүүлэх аргачлалаар 4

улирлын туршид өгөгдөл цуглуулсан. Анхны ЦАС-наас эхлэн дөрвөн улирлын туршид тус бүр 1,000 орчим өрхүүдээс уг судалгааг авсан бөгөөд энэ нь панел өгөгдөл бус харин дөрвөн удаагийн өгөгдөл байснаараа онцлог юм. 2011 оны ЦАС-г хийхээсээ өмнө ҮСХ түүвэр судалгааны аргачлалдаа НҮБ-ийн Үйл ажиллагааны олон улсын ангиллыг оруулсан нь Монголын ЦАС-ны үр дүнг Үндэсний Тооцооны Системд бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй олон төрлийн үйл ажиллагаанд зарцуулж байгаа иргэдийн цаг ашиглалтыг олон улсын хэмжээнд харьцуулах боломжийг олгож өгсөн чухал үйл явдал болсон. ҮСХ 2012 онд Монгол Улсад хийх түүвэр судалгааны аргачлалд International Classification of Activities for Time Use Statistics (ICATUS) буюу Олон улсын цаг ашиглалтын үйл ажиллагааны олон улсын ангиллыг нэвтрүүлсэн ба үүний дараагаар 2015 онд гуравдах ЦАС-г нийслэл хот болон 8 аймгаас санамсаргүй түүвэрлэн авсан 3,972 өрхөөс болон эдгээр өрхүүдийн 12 болон түүнээс дээш настай хүмүүсээс асуулгаар болон өдрийн тэмдэглэл хөтлүүлэх аргачлалаар 4 улирлын туршид өгөгдөл цуглуулж авсан юм. ҮСХ 2011 болон 2015 оны ЦАС-ны үр дүн, тайлангууд, тоон өгөгдлийг нийтэд үнэ төлбөргүй, нээлттэй ашиглуулах зорилгоор ҮСХ-ний нээлттэй өгөгдлийн платформд байршуулсан юм (1212.mn). ҮСХ-оос хийсэн гуравдах удаагийн ЦАС-г шинэ аргачлалаар буюу цаасаар авах ярилцлагын аргыг (the paper-assisted personal interview method) давхар компьютерийн тусламжтай ярилцлага авах (computer assisted personal interview) аргатай хослуулан хийсэн юм (Banzragch, 2018).

Монголын удаах ЦАС-г 2011 онд хийсэн бөгөөд энэ удаа нийтдээ нийт улсын хэмжээнд, бүсийн төлөөлөл бүхий 3,998 өрхүүдээс авсан ба эдгээр өрхүүдийн нийт 12 болон түүнээс дээш настай хүмүүсээс асуулгаар болон өдрийн тэмдэглэл хөтлүүлэх аргачлалаар 4 улирлын туршид өгөгдөл цуглуулж авсан юм. Анхны ЦАС-наас эхлэн дөрвөн улирлын туршид тус бүр 1,000 орчим өрхүүдээс уг судалгааг авсан бөгөөд энэ нь панель өгөгдөл бус харин дөрвөн удаагийн өгөгдөл байсанаараа онцлог юм. 2011 оны ЦАС-г хийхээсээ өмнө ҮСХ түүвэр судалгааны аргачлалдаа НҮБ-ийн Үйл ажиллагааны олон улсын ангиллыг оруулсан нь Монголын ЦАС-ны үр дүнг Үндэсний Тооцооны Системд бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй олон төрлийн үйл ажиллагаанд зарцуулж байгаа иргэдийн цаг ашиглалтыг олон улсын хэмжээнд харьцуулах боломжийг олгож өгсөн чухал үйл явдал болсон. ҮСХ 2012 онд Монгол Улсад хийх түүвэр судалгааны аргачлалд International

Classification of Activities for Time Use Statistics (ICATUS) буюу Олон улсын цаг ашиглалтын үйл ажиллагааны олон улсын ангиллыг оруулсан ба үүний дараагаар 2015 онд гуравдах ЦАС-г нийтдээ нийслэл хот болон 8 аймгаас санамсаргүй түүвэрлэн авсан 3,972 өрхөөс болон эдгээр өрхүүдийн нийт 12 болон түүнээс дээш настай хүмүүсээс асуулгаар болон өдрийн тэмдэглэл хөтлүүлэх аргачлалаар 4 улирлын туршид өгөгдөл цуглуулж авсан юм. ҮСХ 2011 болон 2015 оны ЦАС-ны үр дүн, тайлангууд, тоон өгөгдлийг нийтэд үнэ төлбөргүй, нээлттэй ашиглуулах зорилгоор ҮСХ-ний нээлттэй өгөгдлийн платформд байршуулсан юм (1212.mn). ҮСХ-оос хийсэн гуравдах удаагийн ЦАС-г шинэ аргачлалаар буюу цаасаар авах ярилцлагын аргыг (the paper-assisted personal interview method) давхар компьютерийн тусламжтай ярилцлага авах (computer assisted personal interview) аргатай хослуулан хийсэн юм (Banzragch, 2018).

Хүснэгт 1: Монгол Улсад хийгдсэн Цаг ашиглалтын судалгааны тойм.

	Түүврийн хэмжээ	Түүврийн хүрээ	Ярилцлага хийсэн сарын тоо	Өгөгдөл цуг- луулсан арга	Санхүүжилтийн эх үүсвэр
ЦАС 2000	1,086 өрх	Улаанбаатар хотын 6 дүүрэг, 7 аймаг.	2000 оны 4 сард, 1 сарын турш	Өрхийн асуулга 1, 2 Өрхийн өд- рийн тэмдэглэл бөглүүлэх (цаа- сан хэлбэрээр)	НҮБ-ийн хөгж- лийн Хөтөлбөр, Шведийн Олон Улсын Хөгж- лийн Хамтын Ажиллагааны агентлаг

ЦАС 2007	3,200 өрх	Улаанбаатар хотын 6 дүүрэг, 8 аймаг.	4 улирлын туршид цуглуулсан бөгөөд, 3 дугаар сард 1,000 өрх, 6 дугаар сард 1,000 өрх, 9 дүгээр сард 1,000 өрх, 12 дугаар сард 1,000 өрхөөс ярилцлага авсан.	Өрхийн асуулга 1, 2 Өрхийн өдрийн тэмдэглэл бөглүүлэх (цаасан хэлбэрээр)	НҮБ-ийн хөгжлийн Хөтөлбөр болон ҮСХ-ийн төсвөөр
ЦАС 2011	3,998 өрх, 12 насаас дээш насны 10,693 иргэд	Улаанбаатар хотын 6 дүүрэг, 8 аймаг.	4 улирлын туршид цуглуулсан бөгөөд, 3 дугаар сард 1,000 өрх, 6 дугаар сард 1,000 өрх, 9 дүгээр сард 1,000 өрх, 12 дугаар сард 1,000 өрхөөс ярилцлага авсан.	Өрхийн асуулга 1, 2 Өрхийн өдрийн тэмдэглэл бөглүүлэх (цаасан хэлбэрээр болон компьютерт суурилсан ярилцлага хэлбэрээр)	ҮСХ-ийн төсвөөр
ЦАС 2015	3,972 өрхийн 9,892 иргэд.	Улаанбаатар хотын 6 дүүрэг, 8 аймаг.	4 улирлын туршид улирал болгон 1,000 өрхөөс ярилцлага авсан.	Өрхийн асуулга 1, 2 Өрхийн өдрийн тэмдэглэл бөглүүлэх (цаасан хэлбэрээр болон компьютерт суурилсан ярилцлага хэлбэрээр)	ҮСХ-ийн төсвөөр

ЦАС 2019	3,990 өрхийн 13,499 иргэд	Улаанбаатар хотын 6 дүүрэг, 8 аймаг.	4 улирлын тур- шид уирал бол- гон 1,000 өр- хөөс ярилцла- га авсан.	Өрхийн асуулга 1, 2 (компью- терт суурилсан ярилцлага хэл- бэрээр) Өрхийн өдрийн тэм- дэглэлийг гар утсан дээрх апп ашиглан цуглуулсан. ⁶	ҮСХ-ийн төсвөөр
ЦАС 2023	15,076 өрхийн 17,241 иргэд	Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймаг.	Сар болгон 1,950 орчим өрхүүдээс ярилцлага авсан.	Өрхийн асуулга 1, 2 (утсаар ярилцлага авах хэлбэрээр) Өр- хийн өдрийн тэмдэглэлийг гар утсан дээрх апп болон цахим хуудас ашиглан цуглуулсан. ⁷	ҮСХ-ийн төсвөөр

Source: ҮСХ. (2024). "Цаг ашиглалтын судалгаа" тайлан. 13 дугаар хуудас, Б. Отгонтөгс (2025). *Role of TUS in policymaking in Mongolia*

ҮСХ 4 дэх удаагийн ЦАС-г 2019 онд хийсэн бөгөөд 13,499 хүмүүс бүхий 4,000 өрхүүдээс, болон уг өрхийн 12 болон түүнээс дээш насны гишүүдээс асуулгаар болон өдрийн тэмдэглэлийг хөтлүүлэх аргаар авсан юм. Асуулга нь өмнөх судалгааны адил өрхийн мэдээлэл, хувь хүний мэдээлэл болон 5 наснаас доош насны хүүхдүүдийн талаар асран хамгаалагч нараас нь авсан мэдээлэл, өгөгдлийг цуглуулж авсан юм. Өдрийн тэмдэглэлийн хувьд, 6,312 өрхийн 12 болон түүнээс дээш насны иргэдээр өдрийн тэмдэглэл хөтлүүлж авсан. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн иргэд 10 минутын үргэлжлэх хугацаатайгаар Олон улсын цаг ашиглалтын үйл ажиллагааны ангиллын дагуу 24 цаг буюу 1440 минутад хийсэн үйл ажиллагааг, тухайлбал унтах, усанд ороход зарцуулсан, эсвэл давхардсан үйл ажиллагаа

⁶3, 6 саруудад цаасан хэлбэрийн ярилцлагын хэлбэрийг ашигласан бол 9, 12 саруудад гар утасны апп ашигласан.

⁷CATI болон CAWI аргуудыг ашигласан.

жишээ нь хүүхдээ харах зуураа хоол хийсэн талаар мэдээлэл цуглуулж авсан юм.

ҮСХ 5 дах удаагийн ЦАС-г 2023 онд хийсэн бөгөөд судалгааны үр дүнг үндэсний, бүсийн түвшинд болон байршлаар төлөөлөхүйц чадвартай байхаар түүврийн дизайнаа боловсруулсан. Түүвэрт нийт 15,076 өрх хамрагдсан ба уг өрхийн 12 болон түүнээс дээш насны 17,241 гишүүдээс утсаар, интернетээр, биеээр ярилцлага авах аргаар мэдээллээ цуглуулсан. Нийслэл, аймгийн төв, сумын төвийн өрхийн хувьд ярилцлага өгөгчийн сонголтоор телефон утсаар судалгаа авах (Computer assisted telephone interview - CATI) эсвэл компьютерт суурилсан цахим ярилцлага авах (Computer Assisted Web Interview - CAWI) аргаар судалгааны мэдээллийг цуглуулсан. Хөдөөгийн өрхүүдийн хувьд таблет ашиглан ярилцлага хийх (Computer Assisted Personal Interview - CAPI) болон цаасан асуулга ашиглан ярилцлага хийх (Paper Assisted Personal Interview - PAPI) аргыг хослуулан ашигласан (ҮСХ, 2024). Асуулга нь өмнөх судалгааны адил өрхийн мэдээлэл, хувь хүний мэдээлэл болон өдрийн тэмдэглэл хөтлүүлсэн. Өдрийн тэмдэглэл хөтөлсөн 12 болон түүнээс дээш насны 17,241 иргэдийн 45,3 хувь нь эрэгтэй, 54,7 хувь нь эмэгтэйчүүд байна. Өдрийн тэмдэглэл нь өмнөх судалгааны адилаар 10 минутын үргэлжлэх хугацаатайгаар олон улсын цаг ашиглалтын үйл ажиллагааны ангиллын дагуу 24 цаг буюу 1440 минутыг тусад нь хийсэн үйл ажиллагаа, давхардсан үйл ажиллагааг бүртгэсэн байна. Энэ удаагийн асуулгад ярилцлага өгөгчийн сэтгэл санааны байдал, тухайн өдрийн онцлог (ердийн, хурим ёслолын арга хэмжээтэй, г.м), цаг агаарын байдал зэргийг нэмж оруулсан ба хамгийн чухал нь хүмүүсийн зорчиход зарцуулж буй цагийн мэдээллийг илүү дэлгэрэнгүй гаргах зорилгоор нэмэлт мэдээллийг цуглуулсан байна.

Сүүлийн 4 удаагийн ЦАС-ны талаарх ҮСХ өөрсдийн гаргасан тайлан, асуулга, анхдагч тоон өгөгдлийг 1212.mn платформ дээр тухайн судалгааг хийсний дараах жилд нь нээлттэй, үнэ төлбөргүй тавьсныг нийтдээ 47 мянга орчим татаж авч үзсэн байна. Сүүлийн 4 удаагийн ЦАС-г хэчнээн хүн үзсэн, татаж авсан статистикийг Хүснэгт 2 дээр харуулсан байна. ЦАС-г үзэх, өгөгдлийг нь татаж авах нь өсөх хандлагатай байгааг хүснэгтэс харагдаж байна.⁸

2019 оны ЦАС-ны албан ёсны тайланд 2007, 2011 болон 2019 онуудад Монгол улсын иргэд, хот, хөдөөгийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, 12 наснаас 17 насны

⁸2025 оны 9 дүгээр сарын эхээр.

⁹<http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/154>

Хүснэгт 2: Монголын ЦАС-ны ашиглалт⁹

	Судалгааны өгөгдөл нээлттэй болсон он,сар,өдөр	Нэг өдөрт үзсэн дундаж тоо	Нэг өдөрт татаж авсан дундаж тоо
ЦАС 2023	2024.12.11	62.5	8.1
ЦАС 2019	2020.12.23	41.1	6.7
ЦАС 2015	2017.05.24	23.1	8.0
ЦАС 2011	2014.11.03	61.0	3.4

Эх сурвалж: <http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/TUS/dataset>

хүүхдүүд мөн цагийг хэрхэн зарцуулж байгааг харьцуулж харуулсан байгаа нь ол-ны, багш, оюутнууд, судлаачдын анхаарлыг их татсан байна. 2019 онд 2007 онтой харьцуулахад хүмүүсийн өрх гэрийн ажилд зарцуулсан цаг нь багассан боловч гэр бүлийн иргэдийг цалин хөлсгүй асрахад болон сайн дурын ажил хийх цаг нь нэмэгдсэн байгааг тод хэмжиж харуулсан байдаг. Асрахуйн ажилд зарцуулж буй цагийн өсөлт нь сайн дурын ажилд зарцуулсан цагаас илүү хурдтай өссөн байна (ҮСХ, 2020).

Энэ хэсгийг дүгнэхэд, Монгол Улсад хийгдэж байгаа ЦАС-ууд тодорхой хугацааны давтамжтай, өгөгдөл цуглуулах аргачлал нь сайжирсан, удаа дараагийн түүврийн хэмжээг нэмэгдүүлж, нийтдээ 31,322 өрхүүдээс цаг ашиглалтын өгөгдөл цуглуулж чадсан байна. ОУХБ болон НҮБХХ-ийн 2018 онд хамтран гаргасан тайланд “ЦАС хийж байгаа Азийн орнуудаас зөвхөн Монгол бол Тайланд улсуудад л ЦАС Үндэсний Статистикийн системд нь нутагшиж чадсан судалгаа болсон байна” гэж дүгнэсэн байна (ILO, UNDP, 2018). Гэхдээ Монгол Улсад хийгдэж байгаа ЦАС нь тухайн түүвэрт санамсаргүйгээр хамрагдсан өрхүүдээс давтан авах панель өгөгдөл биш, нэг өрх санамсаргүй байдлаар нэг л удаа хамрагдаж байгаа нэг удаагийн өгөгдөл кросс секцийн өгөгдөл байгаа нь тухайн өрхүүдэд, тухайн гэр бүл, эмэгтэйд цаг ашиглалтын тал дээр яг чухам ямар ямар өөрчлөлт гарч байгаа харуулах боломжгүй байдлаар цуглуулж байгааг хэлэх нь зүйтэй.

Гуравдугаар хэсэг. Монгол Улсад Цаг ашиглалтын өгөгдлийг судалгааны болон бодлогын түвшинд хэрхэн ашиглаж байна?

Судалгааны тоймыг авч үзвэл, 2015 оны болон 2019 ЦАС өгөгдөл ашиглаж хийсэн судалгааг олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд

ихээхэн хэвлүүлсэн байна. ҮСХ 2011, 2015, 2019, 2023 онуудын ЦАС -ний тоон өгөгдлийг нийтэд ил, нээлттэй болгосон тул судлаачид судалгааны олон төрлийн асуулт тавьж судалсан байна. 2011 оны ЦАС-ны асуулгууд, анхдагч тоон өгөгдөл ашиглан 2021 онд King, Randolph, Floro болон Suh нар Өмнөд Солонгос, Гана, Монгол улсын хувьд шууд болон шууд бус асрах ажлын хэмжээг асарч байгаа хүмүүсийн хүйс, асруулж байгаа хүмүүсийн бүлгээр хэмжсэн юм. (King, Randolph, Floro, Suh. 2021). Энэхүү судалгааны гол дүгнэлт нь Монгол улсад нэг өдөрт цалин хөлсгүй асрах ажилд зарцуулсан нийт цагийн 68,4 хувийг эмэгтэйчүүд хийж байгааг хэмжиж бусад улсуудтай харьцуулсан байна. Бусад хоёр улсуудтай харьцуулахад цалин хөлсгүй асрах ажилд эрэгтэй, эмэгтэй нийлээд зарцуулж байгаа цаг нь Монголд Өмнөд Солонгосоос бага, харин Гана улсаас их цаг зарцуулж байгааг харуулсан (Хүснэгт3). Энэ гурван улсад ижил төстэй байгаа шинж бол хүүхэд шууд асрах ажилд нэг өдөрт зарцуулж байгаа цаг бусад хүмүүсийг асрахад зарцуулж байгаагаас хамгийн өндөр байна. Монгол улсад нийтдээ дунджаар нэг өдөрт 102,9 минут цалин хөлсгүй асрах ажилд зарцуулдгийн 47,4 минут буюу 46 хувийг хүүхэд шууд асрахад зарцуулдаг байна.

Т. Мөнгөнсувд болон М. Флоро нар ЦАС -ны 2015 оны өгөгдлийг ашиглан, Тобит загвараар Монгол дах дэд бүтцийн байдал, хүртээмж нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалин хөлсгүй ажлын цагт хэрхэн нөлөөлж байгаа судалсан бөгөөд усны болон ариун цэврийн байгууламж ихээхэн дутмаг байгаагаас хамааран эмэгтэйчүүдийн цалин хөлсгүй ажилд зарцуулах цаг их байгаа бөгөөд нь энэ нь эцэстээ өрхийн орлого, нөхөн үржихүйд сөргөөр нөлөөж байгаа хэмжсэн байна. (Terbish, Floro, 2016).¹⁰

Бодлогын хувьд жендэрийн талаарх бодлогын бичиг баримт, илтгэлд 2015 болон 2019 оны ЦАС -ны албан ёсны тайланд харуулсан тойм статистикийг илүү хэрэглэж байна. Тухайлбал, ҮСХ-ноос гаргасан 2019 оны ЦАС-ны албан ёсны тайланд харуулсан өгөгдлөөр, 18-59 насны эмэгтэйчүүд нэг өдөрт 291 минутыг өрх гэрийн цалин хөлсгүй ажлууд болон цалин хөлсгүй асрах ажилд зарцуулж байгаа бол уг насны эрэгтэйчүүдийн хувьд энэ нь 103 минут байгаа нь Монгол эмэгтэйчүүд цалин хөлсгүй асрахуйн ажилд эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2,8 дахин илүү цагыг зарцуулж байна гэсэн дүгнэлт Монголын Засгийн хэрэгжүүлэх агентлаг Жен-

¹⁰ASIA-PACIFIC POPULATION JOURNAL Vol. 31, No. 1, July 2016

Хүснэгт 3: Гана, Монгол, Өмнөд Солонгос дах цалин хөлсгүй ажилд зарцуулж буй дундаж хугацаа

Улс	Асруулж байгаа хүнд 1 өдөрт зарцуулсан минут	Эмэгтэй асрагч	Эрэгтэй асрагч	Нийт	Эмэгтэйн эзлэх хувь
Гана (ЦАС 2009)	Хүүхдийг шууд асрах	21.3	3.0	24.3	87.5
	Настай хүнийг шууд асрах	4.1	1.8	5.9	70.0
	Шууд бус асрах цаг	28.9	4.6	33.6	86.2
	Нийт асрах цаг	54.3	9.4	63.7	85.2
Монгол (ЦАС 2011)	Хүүхдийг шууд асрах	38.6	8.8	47.4	81.5
	Настай хүнийг шууд асрах	3.2	0.5	3.7	86.1
	Шууд бус асрах цаг	28.5	23.2	51.7	55.2
	Нийт асрах цаг	70.4	32.5	102.9	68.4
Өмнөд Солонгос (ЦАС 2014)	Хүүхдийг шууд асрах	117.8	30.3	148.2	79.5
	Настай хүнийг шууд асрах	5.9	2.9	8.7	67.0
	Шууд бус асрах цаг	77.9	15.9	93.7	83.1
	Нийт асрах цаг	201.6	49.1	250.6	80.4

King, Randolph, Floro болон Suh (2021). Хуудас 10.

дэрийн Тэгш Байдлын Үндэсний Хорооны тайлан бичиг баримт, их сургуулиудын судалгааны тоймд хамгийн их бичигдэж, яригдсан байна.

2019 оны ЦАС-ны өгөгдөл ашиглан Монгол Улсын төрийн өмчийн болон хувийн өмчийн их сургуулиуд олон тооны судалгааг, тухайлбал цалин хөлсгүй асрахуйн салбарт бий болж буй нэмүү өртгийн нийлбэрийн хэмжээ, малчин эмэгтэйчүүдийн цаг ашиглалт, цагийн ядуурал, цалин хөлсгүй асрахуйн ажил хийх нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нийлүүлэлтэд хэрхэн нөлөөлж байгаа талаар, 12-17 насны охид, хөвгүүдийн цалин хөлсгүй асрахуйн ажилд зарцуулж буй цаг нь тэдний боловсролын үр дүнтэй хэрхэн холбоотой байгаа талаар судалгааг хийж байна (Boldbaatar, Banzragch and Dandarchuluun, 2024).

Монгол улсын хөдөлмөрийн насны хүн хүн амд эзлэх эрэгтэйчүүдийн 68,3 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг бол эмэгтэйчүүдийн хувьд ердөө 49 хувь байгаа нь

эмэгтэйчүүд цалин хөлсгүй асрах ажилд ихэнх цагаа зарцуулж байгаагаас хамаарч байгааг харуулж байна. (Asian Development Bank, 2022). Азийн хөгжлийн банкны (АХБ) тооцоолсноор Монгол улс эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог 63,2 хувьд хүргэж чадвал нэг хүнд ноогдох жилийн өсөлтийг 0,5 пунктээр нэмэгдүүлж чадна. (ADB, 2022). Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд жендерийн тэгш байдлыг хангах төрийн бодлого хэрэгжүүлэх нь эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлж эдийн засгийн өндөр өгөөж үзүүлнэ. 2022 онд, МУИС-ийн эдийн засгийн хөтөлбөрийн магистр оюутан судлаач Ц. Оюунзул ЦАС-ний 2019 оны анхдагч өгөгдөл ашиглан 15-аас дээш насны хүн амын дундах цагийн ядуурал, түүний дүр төрхийг хүн амзүйн болон аж байдлын ялгаатай бүлгүүдийн хувьд тодорхойлох, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг судалсан юм. ЦАС-ны тоон мэдээлэл хувь хүний түвшинд бүртгэгддэг тул цагийн ядуурлын үзүүлэлтүүд хувь хүний түвшинд тооцсон байна. Ц. Оюунзулын хэмжсэнээр 1 долоо хоногт 83.2 цаг гэсэн цагийн ядуурлын шугамаас бага цагийг хувийн хэрэгцээний цагт зарцуулсан хүн амыг цагийн ядууралд өртсөн гэж үзсэн ба 2019 оны байдлаар манай улсын 15 ба түүнээс дээш насны хүн амын цагийн ядуурлын хамралтын хүрээ 17.1% байна. Өөрөөр хэлбэл, ойролцоогоор зургаан хүн тутмын нэг нь долоо хоногт 83.2-оос бага цагийг хувийн хэрэгцээний үйл ажиллагаанд зарцуулж байна. Хүйсээр авч үзвэл, эмэгтэйчүүдийн цагийн ядуурлын хамралтын түвшин 17.8% буюу эрэгтэйчүүдийнхээс даруй 1.6 нэгж хувиар илүү байна (Ц. Оюунзул 2022).

2011, 2019 онуудад хийсэн ЦАС-ний өгөгдөл ашиглан уур амьсгалын өөрчлөлт хөдөөгийн малчин эмэгтэйчүүдийн малаа маллах болон асрах ажлын цагт хэрхэн нөлөөлж өөрчлөгдөж байгаа талаар төрийн болон бус өмчийн их сургуулийн судлаачдын баг мөн ажиллаж байна (Amarjargal, 2024). Энэхүү судалгаанд жендерийн харьцуулалт дээр онцгой анхаарал хандуулж, бүх үр дүнг хүйсээр харьцуулжээ.

Монгол Улсад цалин хөлсгүй асрах ажлыг хэн хэн илүү хийж байгаа талаарх судалгааг 2019 оны ЦАС-ны өгөгдөл ашиглан МУИС-ийн судалгааны баг 2024 онд тооцсон байна. (Boldbaatar, Dandarchuluun & Banzragch). Эдгээр судлаачид Монгол Улсад насанд хүрсэн хүн нэг өдрийн нийт 1,440 минутын 23 хувийг дунджаар цалин хөлстэй ажил хийхэд, 15 хувийг цалин хөлсгүй ажил хийхэд, 61 хувийг хувийн эрүүл мэнд, чөлөөт цаг, унтаж амрахад зарцуулж байгаа бол 12-17 насны

548 хүүхдүүдийн хувьд нийт цагийн 4 хувийг цалин хөлстэй ажилд, 8 хувийг цалин хөлсгүй ажилд, үлдсэн 88 хувийг сурах, чөлөөт цаг, унтаж амрахад зарцуулж байгааг тогтоосон байна. Жендерийн хувьд, сурах, өөрийгөө хөгжүүлэх, унтаж амрахад цаг зарцуулалт ялгаагүй байгаа боловч цалин хөлсгүй асрах ажлын хувьд тухайлбал жендерийн хувьд өөр байгааг тогтоосон байна. Жишээ нь, охидыг цалин хөлсгүй асрахуйн ажилд хөвгүүдтэй харьцуулахад 1,9 дахин илүү цаг зарцуулж байгааг хэмжсэн бөгөөд охид нь хөвгүүдийг бодвол дүү нараа харах, эмээ өвөөгөө харах магадлал 16,8 хувь илүү байна. Насанд хүрсэн хүмүүсийн хувьд цалин хөлсгүй асрахуйн ажилд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй харьцуулахад 2,4 дахин илүү цаг зарцуулж байгааг хэмжсэн байна (Boldbaatar, Dandarchuluun & Banzragch in 2024).

Зураг 1. Насанд хүрэгсэд болон 12-17 насны хүүхдүүдийн асрахуйн ажилд зарцуулж байгаа цаг



Эх сурвалж: Boldbaatar, Dandarchuluun & Banzragch, 2024

2019 оны ЦАС-ны албан ёсны тайланд хэмжсэн цалин хөлсгүй асрах ажилд зарцуулж байгаа цагийн хэмжээ, илүү аналитик түвшинд, өгөгдлийг цэвэрлэсний дараа түүвэрт цалин хөлсгүй асрах ажил хийдэг гэж мэдүүлсэн 2,533 хүний өгөгдөл дээр хийх хэмжилт ялимгүй зөрүүтэй байна. Boldbaatar, Dandarchuluun & Banzragch (2024) нарын хэмжсэнээр эмэгтэйчүүд цалин хөлсгүй хүүхэд илүү асардаг бөгөөд давхар асрах ажлыг илүү хийдэг бол эрэгтэйчүүд нь настан болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ илүү асрах хандлагатай байгааг тогтоосон байна.

Цалин хөлсгүй асрах ажил хийж байгаа хүмүүсийн 70 хувь нь давхар асрах ажлыг хамтад нь хийдэг байна (Boldbaatar, Banzragch & Dandarchuluun, 2024).

Цалин хөлсгүй асрахуйн салбар нийт эдийн засгийн хувьд бий болгож байгаа нэмүү өртгийн хувьд их хувь эзэлж байгааг олон улсын судлаачид хэмжсэн байна. Гэвч цалин хөлсгүй, өөрөөр хэлбэл үнэгүй хийж байгаа асрахуйн ажлын нэмүү өртгийн нийлбэр ДНБ-ийг тооцоход орохгүй байгаа билээ. ОУХБ-ийн 2018 онд хийсэн судалгаагаар, асрахуйн салбар дэлхийн нийт ДНБ-ийн 9 хувьтай тэнцүү хэмжээний өртгийг буюу 11 их наяд ам. долларын нийт өртгийг бий болгож байгааг хэмжсэн (ILO, 2018). King, Randolph, Floro, Suh нар 2021 онд 2015 оны Монголын ЦАС-ний өгөгдлийг ашиглан Монгол хүмүүсийн хийж байгаа цалин хөлсгүй асрахуйн ажлын нийт нэмүү өртөг нь 2015 онд Монгол Улсын ДНБ-ний 17 орчим хувьтай тэнцүү хэмжээний өртгийг бий болгосон гэж хэмжсэн (King, Randolph, Floro, Suh, 2021). МУИС-ийн судлаач Г.Уран-Өлзий 2019 оны анхдагч өгөгдлийг ашиглан 2019 онд цалин хөлсгүй асрахуйн эдийн засгийн нийт хэмжээ Монгол Улсын 2019 оны ДНБ-ний 15,3 орчим хувьтай тэнцүү хэмжээний өртгийг бий болгосон гэж хэмжсэн. Монгол Улсад цалин хөлсгүй асрах ажил нь 2019 онд ДНБ-ний 15.3 хувьтай байгаа нь ДНБ-ий 25.3 хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбарын дараа хоёрдугаарт орж байна (ҮСХ, 2023). Иймд цалингүй асрах ажлыг "бодит сектор" гэж хүлээн зөвшөөрч, үнэлэх нь үндэсний нягтлан бодох бүртгэлийн систем, зохистой мөнгө, төсвийн бодлогод чухал ач холбогдолтой юм.

Мөн МУИС-ийн судалгааны баг цалин хөлстэй асрах ажлын хэмжээг тоймлон судласан ба Монгол дахь цалин хөлстэй асрах ажлын үнэлгээ хийх өнөөгийн нөхцөл байдал, судалсан байдал, өгөгдлийн бэлэн байдал, хүртээмжийг тодорхойлжээ. Монгол Улсын хэмжээнд 2021 оны өгөгдлөөр улсын төсвийн зарлагын 29.6, ДНБ-ий 10.6 хувийг цалин хөлстэй асрах ажил эзэлж байгаа ба улмаар Монгол улсын ДНБ-ны 30 орчим хувийг асрах ажил эзэлж байгааг харуулсан байна. Өгөгдлийн бэлэн, хүртээмжтэй байдлаас шалтгаалан дээрх тооцоог дутуу хэмжсэн гэж үзсэн байна. Олон нийт, хувийн хэвшлийн салбарын цалин хөлстэй асрах үйлчилгээний талаар мэдээлэл маш дутмаг, захиргааны мэдээллийг асрах үйлчилгээний төрлөөр нь илүү задлах хэрэгтэйг онцолсон байна (Boldbaatar, Dandarchuluun & Banzragch, 2023).

Хэдийгээр ЦАС-г дөрвөн жил тутамд хийж байгаа ч түүнийг дээр шийдвэр гар-

гах түвшинд хэрхэн хэрэглэж байгаа мэдээлэл маш дутмаг, ил тод жишээ байхгүй байна. Харин энэ чиглэлийн судлаачид ЦАС-ийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, судалгааны үр дүнг гадаад, дотоодын ЭШХ-ууд болон төр захиргааны байгууллагын хуралд илтгэл тавьж олон нийтэд тархааж байна. Гадаадад, 2023 онд International Association of Feminist Economists, 2024 онд the Levy Economic Institute of Bard College conference in the USA, 2022 онд International Care Conference at Seoul National University, Korea зэрэг олон улсын эрдэм шинжилгээний хурал, судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулсан байна. Дотоодод ҮСХ, Жендерийн Тэгш Байдлын Үндэсний Хороо зэрэг төрийн байгууллагууд болон Монгол дахь Азийн сан, Friedrich Ebert сан зэрэг олон улсын төрийн бус байгууллагууд, орон нутгийн төрийн бус байгууллага зэрэг иргэдийн төлөөлөгчтэй хамтран Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ба Монголын үндэсний феминист сүлжээ форум, хурал зохион байгуулж, асрахуйн эдийн засгийн талаар ЦАС -ны тайланг мэдээллийг ашиглаж байна (ХНХЯам, ЖҮХ, АХБ, 2019). Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан ЦАС-ны үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээн дэлгэрүүлсний үр дүнд улс орны цалин хөлсгүй асрах ажлын цар хүрээ, ач холбогдлыг олон нийт хүлээн зөвшөөрч, бодлого боловсруулагчид энэ талаар илүү их мэдлэгтэй болж байна.

ЦАС 2011 болон 2019 оны өгөгдөл ашиглан, Banzragch, O., Meurs, M., Boldbaatar, M., Amarjargal, A., Pioneer, Ts, нар хөдөөгийн малчин болон сумын төвийн өрхүүдэд цалин хөлстэй ажил, мал маллах, гэрийн ажил, асрах ажилд хэдийн хугацааг эрэгтэй эмэгтэй хүмүүс хэрхэн гүйцэтгэж байгааг хэмжин гаргаж олон улсын судлаачдын багийн хамтарсан номонд хэвлүүлэх гэж байна. Хүснэгт 3-т харуулсны дагуу, 2019 онд 2011 оны байдалтай харьцуулахад хөдөөгийн малчин эрэгтэйчүүдийн болон эмэгтэйчүүдийн нэг өдөрт хамгийн их цагаа зарцуулдаг хэсэг бол хувийн хэрэгцээ буюу унтах, хооллох, хувийн эрүүл мэнд, ариун цэвэр сахих ажилд зарцуулж байна. Хоёрдугаарт, мал маллах ажилд их цаг зарцуулж байна, эрэгтэйчүүд 2 цаг, эмэгтэйчүүд 1 цаг илүү зарцуулж байна. байна. Хүснэгт 4-өөс гарч байгаа нэг том дүгнэлт бол, 2019 онд 2011 онтой харьцуулахад хөдөөгийн малчид болон сумын төвийн иргэдийн хувьд асрах ажилд зарцуулж байгаа цаг нь бүгдийн хувьд нэмэгдсэн байна.

Ийнхүү Монголд ЦАС-г ашиглан цалин хөлсгүй асрах ажлын талаарх хэмжилт, судалгааны ажил ихээхэн ахицтай байгаа. Гэсэн хэдий ч асрахуйн эдийн засгийн

Хүснэгт 4: Үйл ажиллагаа хөдөө болон сумаар

Үйл ажиллагаа (ажлын өдөр)	Хөдөө				Сум			
	2011		2019		2011		2019	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Цалин хөлстэй ажил	7.69	7.04	14.99	15.12	54.72	47.99	60.51	52.19
Мал маллах	120.09	65.90	122.08	63.17	24.92	13.02	22.28	9.35
Өрх гэрийн ажил	21.67	68.43	19.92	60.21	25.34	55.03	21.54	51.70
Асрах ажил	2.72	9.49	3.04	10.34	5.13	11.45	4.92	9.92
Боловсрол, сайн дурын ажил	1.12	4.08	1.13	4.21	3.56	5.36	2.81	4.66
Чөлөөт цаг	38.94	26.09	36.11	28.88	55.28	37.58	57.87	40.71
Хувийн хэрэгцээ	183.29	158.23	167.99	159.52	171.48	155.42	173.19	161.68

Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2011, 2019)

мэдээлэл дутмаг байгааг бүрэн дүүрэн нөхөх боломжгүй. Иргэд болон төрийн бус байгууллагуудын дэргэдэх хүүхэд харах үйлчилгээний төвүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлбөртэй асрамжийн үйлчилгээний талаар мэдээлэл хомс байна. Ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ямар төрлийн төлбөртэй тусламж үзүүлэх талаар нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байна. Хөдөөгийн малчин өрхүүдэд хөлстэй асрах үйлчилгээг хэрхэн хүргэх талаар судалгаа, бодлого дутагдалтай байна.

Судалгааны дараагийн хэсэгт, ЦАС-ийн бодлоготой холбоотой судалгааны дүн шинжилгээг Монгол Улсын бодлого боловсруулах, бодлогын шинжилгээнд хэрхэн ашиглаж байгаа талаар 2024 онд бид ҮСХ, Монгол Улсын Төв банк, Монгол Улсын Их Хурлын Төсвийн хяналтын хороо, Эдийн засаг, хөгжлийн яам, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Жендерийн Үндэсний хороо, МУИС, Хүмүүнлэгийн их сургуулийн нийт 14 албан тушаалтан, судлаач, шинжээч, профессорууд оролцсон ярилцлага хийв. Монгол Улс, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Эдийн засгийн судалгааны хүрээлэн, “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ, НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газартай уулзаж ярилцлаа. Тэдний 66.7 хувь нь эмэгтэй, 33.3 хувь нь эрэгтэй байна. Ярилцлагад оролцогчдын дундаж нас 45.8 орчим бөгөөд 18-20 орчим жил ажилласан туршлагатай. ҮСХ-ны 2 албан тушаалтнаас цаг ашиглалтын мэдээлэл цуглуулах талаар, үлдсэн 12 хүнээс мэдээлэл хэрэглэж байгаа талаар асуусан. Ярилцлагад оролцогч 12 бодлого боловс-

руулагчаас 7 хүн буюу 58,4 хувь нь бодлого боловсруулагчид, 3 хүн буюу 25 хувь нь эрдэм шинжилгээний байгууллага, 2 эмэгтэй буюу 16,6 хувь нь иргэний нийгмийн төлөөлөл байна. Судлаач, бодлого боловсруулагчдын 12 хүний 88.8 хувь нь МТҮС-ийн талаар мэдлэгтэй, харин Монгол банкны 2 бодлого судлаач (16,6 хувь) судалгааны талаар мэдлэггүй гэж хариулжээ. Цаг ашиглалтын мэдээллийн талаар мэддэг хүмүүсийн 88.8 хувь нь мэдээлэл авахад ямар ч саад бэрхшээл байхгүй, ихэнх нь цахим орчинд хялбар нэвтрэх боломжтой гэж хариулсан байна. Бодлого боловсруулагчдаас ЦАС-ийн өгөгдлийг хэрхэн ашигласан талаар асуухад тэд дараах байдлаар хариулав.

- ЦАС-н 2019-ийн өгөгдлийг “2023 онд хүний хөгжилд чиглэсэн эрчим хүчний шилжилтийн тухай” судалгааны тайлангийн бүлэг бичихэд ашигласан.

- Тогтвортой хөгжлийн зорилтуудын үзүүлэлтүүдийн тайланг бичихэд ЦАС-н 2019 мэдээллийг ашигласан.

- Нийслэл Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн хөгжилд тулгарч буй бэрхшээл, сорилтод дүн шинжилгээ хийхэд ҮСХ-ний тоо баримтыг ашигласан.

- Жендэрийн тэгш байдлын үндэсний хорооны жендэрийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтад ЦАС-н 2019 тайланг ашигласан. Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны хувьд 2023 онд Хөдөлмөрийн тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлт дээр ажиллахдаа ЦАС-ны үр дүнг буюу хүүхдээ харах эрэгтэй эмэгтэй хүмүүсийн цагийн зарцуулалт зэргийг ашигласан гэж хариулсан байна. Эрдэм шинжилгээний 3 судлаачаас 1 нь судалгааны мэдээллийг ашигладаггүй гэж хариулжээ. ЦАС-ийн өгөгдлийг ашигласан үлдсэн хоёр эмэгтэй профессор дараах байдлаар тайлбарлав. Үүнд:

- ЦАС 2019 оны түүхий мэдээллийг малчин эмэгтэйчүүдийн цалингүй хөлсгүй асрах ажилд зарцуулсан цаг, мал маллах цаг, цаг уурын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж буйг шинжлэх судалгааны нийтлэлд ашиглаж байна. 2019 оны ЦАС-ны тайлангийн 4-р бүлэг, өрхийн цалин хөлсгүй асрах ажлын талаарх мэдээлэл, тооцоолол өгөгдлийн хамгийн чухал хэсэг юм. ЦАС-ийн мэдээллийг ашигласан хүмүүс малын тоо толгой, улирлын чанартай мал аж ахуйн үйл ажиллагаа, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг мал аж ахуйд зарцуулсан цаг хугацааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл дутмаг байгаагаас бусад тохиолдолд судалгааны мэдээллийн чанарын талаар хангалттай хариулт өгч байна. Сүү, сүүн бүтээгдэ-

хүүний мэдээлэл цуглуулах явцад өгөгдлийн чанарын хяналт хангалтгүй байгаа талаар судлаач хариулав.

- ЦАС-н 2019 оны түүхий тоон өгөгдлийг цэвэрлэн, Монгол улсын цалин хөлсгүй асрахуйн эдийн засгийн хэмжээг тооцоолоход ашигласан,

- Тус улсын цалингүй хөлсгүй асрагч болон асрагчдад дүн шинжилгээ хийхэд ижил судалгааны өгөгдлийг ашигласан. Төрийн бус байгууллагуудын хувьд орон нутгийн ТББ болон НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын 2 эмэгтэй дараах байдлаар хариулав.

- НҮБ-ын Хүүхдийн сангийн оффис нь Монгол Улсын ҮСХ-той хамтран Олон Үзүүлэлттэй Кластер Судалгаанд хүүхдийн цаг ашиглалтын талаар нэмэлт шинэ модуль оруулах,

- ЦАС-н 2015 болон 2019 оны мэдээллийг эмэгтэйчүүдийг чадавхжуулах, цалингүй асрах ажлын талаарх илтгэл, постерт ашигласан гэж тус тус хариулсан байна.

Эдгээр хариулт нь яамны, бодлого боловсруулагч мэргэжилтнүүд цаг ашиглалтын статистик мэдээлэлтэй бага харьцаж байгааг нотолж байна. Төв банк, Сангийн яам зэрэг макро эдийн засгийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэгч хоёр гол байгууллага нь бодлого боловсруулах, төсвийн төлөвлөлт, бодлогын дүн шинжилгээ хийхдээ ЦАС-ийг ашиглахгүй байна.

Энэ бүлгийн анализыг дүгнэж хэлэхэд, хүмүүсийн цаг ашиглалтын өгөгдлийн цаана хүмүүс, ялангуяа хот, хөдөөгийн эмэгтэйчүүд яагаад албан секторт олноор ажиллахгүй байна, төрөлтийн түвшин яагаад алгуур буурч байна, яагаад нэг хүнд ноогдох үндэсний орлогын хэмжээ нэмэгдэхгүй байна, яагаад цалингийн хүйсийн ялгаа буурахгүй байна гэдэг макро эдийн засаг, өсөлт, хүн амын өсөлт, орлогын талаарх чухал чухал тулгамдсан асуултуудад хариулт өгөх өгөгдөл байгааг, уг өгөгдлийг ашиглан хийсэн нарийвчилсан эдийн засаг, эконометрикийн судалгааг бодлогод зөв хэрэглэх нь тухайн бодлогын байгаа онох хамгийн дөт зам болох талаар ойлголт хомс байгааг чанарын судалгаа харуулж байна.

Дөрөвдүгээр хэсэг. Дүгнэлт

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо 2000 оноос хойш нийт зургаан удаа Цаг ашиглалтын судалгааг зохион байгуулж, 31,322 өрхөөс цаг ашиглал-

тын өгөгдлийг цуглуулсан нь асрахуйн эдийн засгийн цар хүрээ, бүтэц, нийгэм-эдийн засгийн бодлогод нөлөөлөх чухал мэдээллийн эх сурвалж болж байна. Судалгааны аргачлал, түүврийн төлөөлөх чадвар, өгөгдөл цуглуулалтын технологи сайжирч, өгөгдлийн хүртээмж нэмэгдсэн нь судлаачид, их дээд сургуулийн багш, оюутнуудын дунд өргөн хэрэглэгдэж буйг харуулж байна.

Гэвч бодлого боловсруулагчдын дунд ЦАС-ын өгөгдлийг ашиглах явдал хангалтгүй байгааг чанарын судалгаа харуулж байна. Төв банк, Сангийн яам зэрэг макро эдийн засгийн бодлого тодорхойлогч байгууллагууд цаг ашиглалтын өгөгдлийг бодлогын дүн шинжилгээндээ төдийлөн тусгаж чадахгүй байгаа нь эдийн засгийн далд хүчин зүйлсийг үл тооцох, бодлогын алдаа гаргах эрсдэлийг дагуулж байна.

ЦАС нь зөвхөн иргэдийн өдөр тутмын цагийн хуваарийг илэрхийлэх бус, цалин хөлсгүй асрах ажил, жендерийн тэгш бус байдал, хөдөлмөрийн зах зээлд оролцох боломж, цагийн ядуурал, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө зэрэг олон талт асуудлыг хэмжих, тайлбарлах боломжтой чухал өгөгдлийн эх сурвалж юм. Судалгааны үр дүнгээр эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөдөөгийн иргэдийн цаг ашиглалтын онцлог, тэгш бус байдал тодорхой харагдаж байгаа нь бодлого боловсруулахад зайлшгүй анхаарах шаардлагатайг илтгэж байна. Цаашид ЦАС-ын өгөгдлийг илүү үр дүнтэй ашиглахын тулд:

- Панель өгөгдөл цуглуулж, цаг хугацааны өөрчлөлтийг илүү нарийвчлан судлах,
- Бодлого боловсруулагчдын чадавхийг нэмэгдүүлэх, өгөгдлийг ашиглах сургалт, аргачлал нэвтрүүлэх,
- Асрахуйн эдийн засгийг бодит сектор гэж хүлээн зөвшөөрч, ДНБ-д тусгах аргачлал боловсруулах,
- Хөдөөгийн болон орон нутгийн асрах үйлчилгээний хүртээмж, өгөгдлийн чанар сайжруулах шаардлагатай байна.

Ийнхүү ЦАС нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн бодлогын суурь өгөгдөл болох чадавхтай бөгөөд түүнийг зөв ашиглах нь илүү оновчтой, тэгш, үр өгөөжтэй бодлого хэрэгжүүлэх үндэс болно.

Ашигласан материал

- ADB. (2022). *Impact of gender inequality on long-term economic growth in Mongolia*. Retrieved from <https://www.adb.org/sites/default/files/publication/850426/eawp-056-gender-equality-economic-growth-mongolia.pdf>
- Amarjargal, A. (2024). *Climate change impact on unpaid care work among herder women*. A manuscript submitted to the journal *Economics: Theory and Practice*, National University of Mongolia.
- Banzragch, O. (2018). *Data2X. Invisible No More? Country case studies. Mongolia: Time Use Surveys and Policy Case Study*. Retrieved from <https://data2x.org/wp-content/uploads/2019/05/Data2X-Invisible-No-More-Volume-2.pdf>
- Banzragch, O., & Boldbaatar, M. (2022). *The unpaid care sector in Mongolia*. Presentation at the 2022 International Care Conference, Seoul National University, Korea.
- Banzragch, O., Boldbaatar, M., Meurs, D., Dandarchuluun, Kh., Baatar, D., Ganbaatar, Ts., Ulziikhishig, U., & Bayaraa, N. (2024). *Mapping Care Economy in Mongolia - Desk Study* [Unpublished]. Ulaanbaatar, Mongolia.
- Banzragch, O., Meurs, M., Boldbaatar, M., Amarjargal, A., & Pioneer, Ts. (2025). *Care provision in Mongolia: The case of nomadic households*. In Ito Peng (Ed.), University of Toronto, Canada.
- Boldbaatar, M., Banzragch, O., & Dandarchuluun, Kh. (2023). *Estimating paid care sector in Mongolia*. Poster presented at the 2023 IAFEE Conference.
- Coyle, D., & Nakamura, L. (2022). Time Use, Productivity, and Household-centric Measurement of Welfare in the Digital Economy. *International Productivity Monitor*, 42, 165--186.
- King, E.M., Randolph, H.L., Floro, M.S., & Suh, J. (2021). Demographic, health, and economic transitions and the future care burden. *World Development*, 140.
- National Statistics Office of Mongolia. (2016). *Report on Time-Use Survey 2015*. Retrieved from <http://web.nso.mn/nada/index.php/catalog/124>

- National Statistics Office of Mongolia. (2020). *Report on Time-Use Survey 2019*. Retrieved from <http://web.nso.mn/nada/index.php/catalog/124>
- National Statistics Office of Mongolia. (2020). *Report on Time-Use Survey 2011*. Retrieved from <http://web.nso.mn/nada/index.php/catalog/124>
- Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Жендерийн Үндэсний Хороо, Азийн Хөгжлийн Банк. (2019). *Жендерийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ*. Retrieved from <https://www.ncge.gov.mn/wp-content/uploads/2023/12/30.pdf>
- Ц. Оюунзул. (2022). *Монгол Улс дах цагийн ядуурал: Цаг ашиглалтын судалгаанд суурилсан шинжилгээ*. Retrieved from <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=127182>
- Г. Цэвээндолгор. *Цалин хөлсгүй асрахуйн ажил нь эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нийлүүлэлтэд нөлөөлөх нь*. Retrieved from <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=124912>
- Г. Уран-Өлзий. (2023). *Цалин хөлсгүй асрах ажлын мөнгөн дүнгээр хэмжих нь*. *Journal of Demography*, 2023(33). Retrieved from <https://catalog.num.edu.mn/cgi-bin/koha/opac-detail.pl?biblionumber=131837>